БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХТАЙВАН

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН БОЛОМЖИЙГ САЙЖРУУЛАХ /УВС АЙМАГ, УЛААНГОМ СУМЫН 9,10 БАГ, ХОВД СУМ/ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2020.05.11 Дугаар: 2020/Ц-33 Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	1.1	"Увс цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийн 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 66/2020, 68/2020, 69/2020 тоот техникийн нөхцлүүд,
	1.2	Эрчим хүчний сайдын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 102 тоот тушаал
2. Байршил		Увс аймаг, Улаангом сумын 9, 10 баг, Ховд сум
3. Обьектийн бүрэлдэхүүн, хүч чадал	3.1	Увс аймаг, Улаангом сумын 9, 10 баг, Ховд сум эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийн цахилгаан хангамж,
	3.2	Ховд суманд АТП-77, АТП-200 дэд өртөөний 7 км 0,4 кВ-ын ЦДАШ-ыг УКШ-9 маркийн төмөр бетон тулгуур бүхий СИП кабель болгон шинэчлэх, АТП-200, 77, 78 дэд өртөөний толгойн тоолуур болон бүх хэрэглэгчдийг /250 цэгт/ 1 фазын баталгаат бүрэн электрон тоолуур, концентратор, коллектор суурилуулах, тоолуурын 3,6-тай шит суурилуулж айл өрхийг холбох
	3.3	Улаангом сумын 9 дүгээр багт Улиасны хэв гаргалгаанаас 6 кВ-ын 300 метр ЦДАШ татах, 6/0,4 кВ-ын 160 кВА дэд станц шинээр барих, 0,4 кВ-ын 0,7 км ЦДАШ барих, тоолуурын хувиарилалтын 3, 6-тай 24 хайрцаг суурилуулж айл өрхийг хуучин тоолууранс холбох,
	3.4	Улаангом сумын 10 дугаар багт Улиасны хэв гаргалгаанаас 6 кВ-ын 300 метр ЦДАШ татах, 6/0,4 кВ-ын 160 кВА дэд станц шинээр барих, 0,4 кВ-ын 0,7 км ЦДАШ барих, тоолуурын хувиарилалтын 3, 6-тай 24 хайрцаг суурилуулж айл өрхийг хуучин тоолууранс холбох,
	3.5	Шинээр баригдах дэд өртөө нь MNS 6520:2015 стандартын шаардлагыг хангасан байх, дэд өртөөний төрөл болон техникийн шаардлагыг ашиглагч байгууллагатай зөвшилцөж зураг төсөлд тусгах, байршлыг ашиглагч байгууллагатай зөвшилцөх,
	3.6	Дэд өртөөний трансформатор нь MNS GOST

52719:2014 стандартын шаардлагыг хангасан, хүчдэл тохируулга нь 5 тавилтай, сүүлийн үеийн бага алдагдалтай трансформатор байх,

3.7 0,4 кВ-ын оруулга ба гаргалгаануудыг кабель шугамаар төлөвлөх, кабель шугам нь MNS 6519:2015 стандартын шаардлагыг хангасан, Монгол орны цаг уурын нөхцөл болон галд тэсвэртэй нөхцөлийг хангасан хоолой ашиглаж кабель шугамыг хамгаалах,

3.8 0,4 кВ-ын щит нь хүчдэл, гүйдэл хэмжих хэрэгсэлтэй, DLMS протокол дэмждэг бүрэн электрон тоолуур, гүйдлийн трансформатор нь тусдаа хайрцаганд суурилуулах,

3.9 Дэд өртөөний газардуулга, 0,4 кВ-ын ЦДАШ-ын давтан газардуулгыг норм, дүрмийн дагуу хийх,

3.10 Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам нь MNS 6518:2015, MNS 6519:2015 стандартын шаардлага хангасан байх ба утасны дамжуулагчийн хөндлөн огтлолыг хэрэглээний ачаалал болон хэтийн төлөвтэй уялдуулан тооцоогоор сонгох,

3.11 ЦДАШ-ын болон кабель шугамын трассыг орон нутаг болон ашиглагч байгууллагатай зөвшилцөн сонгох, тухайн орон нутгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, газар орчны төлөв байдал, инженер геологийн дүгнэлтийг гаргах,

3.12 6 ба 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур нь MNS:4232-2011 стандартын шаардлагыг хангасан байх,

3.13 0,4 кВ-ын агаарын шугамын дамжуулагч нь бүрээстэй /СИП/ маягийн утас байх ба хөндлөн огтлолыг тооцоогоор сонгох,

3.14 Хэрэглэгчийн тоолууруудыг 0,4 кВ-ын ЦДАШ-ын тулгуур дээр нэгдсэн тоолуурын хайрцаганд суурилуулах, щитний газардуулгын зургийг төсөлд тусгах,

3.15 Тоолуурын хайрцагны зураг төсөл нь ашиглагч байгууллагын тавьсан шаардлагыг хангасан байх,

3.16 Хэрэглэгчийн тоолуур нь олон Улсын IEC 62056 цуврал стандартын шаардлагыг хангасан байх ба Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий, ашиглагч байгууллагын шаардлагыг хангасан байх,

4. Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага

4.1. Дэд станцад суурилагдах тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний өндөрлөг, олон улсын IEC стандартын шаардлагыг хангасан орчин үеийн дэвшилтэт технологитой байх,

4.2. Тооцоогоор сонгогдсон тоног төрөөрөмжүүд нь Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх,

5.	Инженерийн хангамж	Хүчний болон гэрэлтүүлгийн самбарт давтан газардуулга, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах, техникийн нөхцөлд дурдсан бусад инженерийн хангамж,
6.	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Нэг үе шаттай, техникийн нөхцлийн хүчинтэй хугацаанд
7.	Цаашид өргөтгөх эсэх	Цаашид өргөтгөх боломжтойгоор зай талбайг тооцож зураг төсөлд тусгах,
8.	Барих хугацаа	2020 он
9.	Гүйцэтгэгч байгууллага	“Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх,
10.	Захиалагч байгууллага	Эрчим хүчний яам
11.	Зургийн байгууллага	“Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх
12.	Онцгой нөхцөл	

12.1. Зураг төслийг Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн мехник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэмийн дагуу гүйцэтгэх,

12.2. Зураг төслийг улсын экспертизед оруулахын өмнө ашиглагч байгууллага болон холбогдох газруудаар хянуулж, зөвшөөрөл авсан байх,

12.3. Техникийн нөхцөлд дурдсан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах,

БОЛОВСРУУЛСАН:
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ш.ГАНЗОРИГ